



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#8

2022 он

XI сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

МОНГОЛЫН БОЛОВСРОЛ ӨНӨӨДӨР

Үндэсний нэгдсэн судалгааны хүрээнд "0-24 насны хүүхэд залуучуудын боловсролын үйлчилгээнд хамрагдалт-2022" судалгааны мэдээлэл цуглуулагч нарыг чадавхжуулах сургалтууд 21 аймагт явагдлаа.



Нийслэлийн дүүргүүдэд хийсэн сургалтууд



"МОНГОЛЫН БОЛОВСРОЛ ӨНӨӨДӨР"

Үндэсний нэгдсэн судалгааны нийт хамрагдах өрхийн тоо, сургагч, судлаачдын тоо /нийслэлийн дүүрэг, аймаг/

Дд	Орон нутаг дахь судалгааны ажилтан бэлтгэх (танхимаар)	Өрхийн тоо	Нэгж хариуцсан судлаач
1	Багануур дүүрэг	8,557	43
2	Баянгол дүүрэг	62,784	314
3	Баянзүрх дүүрэг	104,881	524
4	Налайх дүүрэг	10,263	51
5	Сонгинохайрхан дүүрэг	90,231	451
6	Сүхбаатар дүүрэг	39,302	197
7	Хан-Уул дүүрэг	56,874	284
8	Чингэлтэй дүүрэг	38,413	192
9	Багахангай дүүрэг	1,222	6
Нийслэлийн нийлбэр		412,527	2,063
10	Архангай аймаг	28,285	141
11	Баян-Өлгий аймаг	25,630	128
12	Баянхонгор аймаг	26,625	133
13	Булган аймаг	19,069	95
14	Говь-Алтай аймаг	16,521	83
15	Говь-Сүмбэр аймаг	5,261	26
16	Дорноговь аймаг	21,115	106
17	Дорнод аймаг	24,720	124
18	Дундговь аймаг	14,847	74
19	Завхан аймаг	21,616	108
20	Өвөрхангай аймаг	34,424	172
21	Өмнөговь аймаг	23,164	116
22	Сүхбаатар аймаг	18,817	94
23	Сэлэнгэ аймаг	29,947	150
24	Төв аймаг	28,574	143
25	Увс аймаг	22,315	112
26	Ховд аймаг	23,329	117
27	Хөвсгөл аймаг	39,652	198
28	Хэнтий аймаг	25,141	126
29	Дархан-Уул аймаг	29,512	148
30	Орхон аймаг	29,074	145
АЙМГИЙН НИЙЛБЭР		507,638	2,538
НИЙЛБЭР		920,165	4,601

Хэлэлцүүлэг 1

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр иргэний нийгэм, олон нийтийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, үзэл баримтлалын бүтэц, энэ хүрээнд хийгдэх ажлуудын талаар санал солилцлоо.



Хэлэлцүүлэг 2

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн Дэлхийн банкны “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд “Бага боловсролын монгол хэлний сургалтад ашиглах эхийн сан бүрдүүлэх” төслийг хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд “Бага боловсролын монгол хэлний сургалтын эх сонгох, зохиох жишиг шаардлага, шалгуур” боловсруулж, монгол хэл, уран зохиолын мэргэжлийн бүлэг, хүүхдийн зохиолч, хүүхдийн тасгийн номын санчид, хэвлэлийн газрын хүүхдийн редакцын төлөөлөл, нийслэл болон хөдөө орон нутгийн бага ангийн багш, сургалтын менежер нийт 200 гаруй оролцогчдыг хамруулан хэлэлцүүлгийг танхим болон онлайн хэлбэрээр зохион байгууллаа. Төслийн үр дүнд I-V анги тус бүрээр шаардлага, шалгуурт нийцсэн сургалтын эхийн сан бүрдэх юм.



Хэлэлцүүлэг 3

БСҮХ-ийн захиргааны хурлаар Элф Верс ХХК-ний гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ, Боловсролын төслийн менежер Б.Билигсайхан нар СӨБ-ын чиглэлээр хэрэгжүүлж буй Лайф Трий хөтөлбөрийн агуулга, арга зүйгээ танилцууллаа.

Судалгаа 1

Манлайлагч оюутны манлайллын ур чадварт нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа хийгдэж, өгүүлэл болж гарлаа. Судалгааны үр дүнгийн талаар товчхон дурдвал Манлайлал нь удамшдаггүй бөгөөд цөөн хэдэн хүмүүст заяасан онцлог шинж чанар биш гэдгийг баталж, энэ нь бүхлээрээ хүний зан байдалтай холбоотойг судалсан байна.

Манлайллын туршлагын нөөц буюу LPI (leadership practices inventory) юм. LPI арга нь загвар манлайллын дараах таван чадварт шинжилгээ хийдэг. Үүнд:

- Үлгэр дуурайлтай байх /MODEL the way/
- Нийтлэг алсын харааг бий болгож, түүнд чиглүүлэх /INSPIRE a shared vision/
- Өөрийгөө сорих /CHALLENGE the process/
- Бусдад боломж өгөх /ENABLE to others act/
- Сэтгэлийн урам өгөх /ENCOURAGE the heart/ зэрэг болно.

Эдгээр таван туршлагаас тасралтгүй суралцаж, дадлагажин өөрийгөө хөгжүүлснээр үлгэр жишээч манлайлагч болох боломж хүн бүрт байдгийг судалгаагаар нотолсон юм.

Судалгаа 2

Боловсролын зорилтыг хангахад санхүүжилтийн механизм нь “Тэгш байдлыг хангах”, “Сонгох боломж, эрх чөлөөг хангах”, “Үр ашиг, үр дүнг хангах”, “Бүтээмж, эдийн засгийн өсөлтийг хангах” гэсэн үндсэн үүрэгтэй байна [Ross, Levacic (1999). Needs-based resource allocation in education: via formula funding of schools].

Хувьсаж буй боловсролыг дэмжихэд санхүүгийн ямар шинэчлэл хийх хэрэгтэй байгааг “Боловсролын санхүүжилтийг бэхжүүлэх, солонгоруулах”, “Боловсролын санхүүжилтийн тэгш, хүртээмжтэй байдлыг сайжруулах”, “Боловсролын санхүүжилтийн үр ашигтай байдлыг сайжруулах” гэсэн шалгуураар тодруулж нэгтгэсэн байна.

Судалгаа 3

Боловсролын хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох баримт бичгийн судалгаа хийж судалгааны үр дүнд нь 2 эрдэм шинжилгээний өгүүлэл гарлаа.

Боловсролын ирээдүйтэй холбоотой нэр бүхий бүтээлүүдийг тодорхой үзүүлэлтийн дагуу судалж, боловсролын ирээдүйн хөгжлийн үзэл баримтлал, бодлого чиглэлийг тодорхойлж буй байдлыг илрүүлэх нь боловсрол судлаачдын хувьд төдийгүй цаашид Монгол Улсын боловсролын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход ач холбогдолтой байх тул бид энэхүү шинжилгээг хийсэн болно.

Шинжилгээний үр дүнд боловсролын ирээдүйн чиг хандлагыг “Ирээдүйн нийгмийн иргэн, Боловсролын ирээдүйн хөгжлийн үзэл баримтлал, боловсролын тогтолцооны өөрчлөлт болон боловсролын бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” гэсэн хүрээнд тодорхойлох боломжтой байна. Энэ нь шинжилгээнд авсан баримт бичгүүдийн агуулгыг бүрэн хамрахгүй боловч боловсролын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход зайлшгүй авч үзэх асуудал мөн юм.



<https://mnier.mn/journal/index.php/research/article/view/76> Судалгааны дэлгэрэнгүй холбоосоор орж уншина уу.

Хөтөлбөрийн харьцуулсан шинжилгээ




Монгол Улсын бага, дунд боловсролын шинэчлэлийн хүрээнд Европын Холбооны нэгдсэн хүрээний англи хэлний түвшнийг баримжаалан VI-VII, VIII-IX ангид Low A1 - Low A2 түвшнийг, бүрэн дунд боловсролын 10-12-р ангид заавал судлах хичээлийн хөтөлбөрийг Mid A2 – Low B1 түвшнийг баримжаалан англи хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байдаг. Англи улсын Pearson англи хэлний сургалтын хөтөлбөрийг V-IX ангид

туршиж хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын англи хэлний сургалтын хөтөлбөрийн агуулгатай харьцуулсан тохирлын шинжилгээ хийгдэв.

“Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ”-г хэрэгжүүлж байгаатай холбож Pearson англи хэлний хөтөлбөрийг монгол улсын англи хэлний сургалтад нэвтрүүлэх нь технологийн дэвшил хурдацтай явагдаж байгаа энэ үед боловсролын тулгамдсан асуудлуудыг сургалтын технологи ашиглах замаар шийдэх, тэрээр ЕБС-ийн англи хэлний боловсролын эко систем бүрдэхэд нөлөөлөх хүчин зүйл болох юм гэж үзэж байна.

Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III



Төрийн албан хаагчдад зориулсан “Үндэсний бичиг” аппликейшнийг 2022 оны 11 сард “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын хүрээнд БШУЯ-ны захиалгаар БСҮХ-ийн МХБСАТ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд ахлан, баг бүрдүүлж, хийж гүйцэтгэх ажлыг эхлүүлээ.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Үндэсний бичиг” монгол бичигт сургах анхны аппликейшнийг БСҮХ-ийн МХБСАТ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд багийн гишүүдийн хамтаар бүтээж дууслаа. Энэхүү аппликейшн нь насанд хүрэгчдийн сургалтын онцлогуудыг харгалзсан, төрийн албан хаагчдад нээлттэй, сонголттой, орон зай, цаг хугацааг үл хамааран монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх боломжтой болсноороо онцлогтой юм. Аппликейшн дараах цэсүүдтэй:

1. Монгол бичгийн цагаан толгой (монгол бичгийн бичмэл үсгийн тигийг эхлэх болон дуусгах дараалал)
 2. Монгол бичгийн үндсэн агуулгыг тулгуур дохиогоор илэрхийлсэн 100 ширхэг үзүүлэн
 3. Видео хичээлүүд (Монгол бичгийн тулгуур ойлголтуудаар бүтээсэн үзүүлэнгийн агуулгыг дэмжсэн 3 минутын хичээл)
 4. Хичээлийн агуулгыг бататгах сорилууд 1000 сорил
- Зохиогчийн багийнхан цаашид аппликейшны хөгжүүлэлтийн ажлыг төлөвлөж байгаа бөгөөд үүнд:
- Унших бичил эхүүд
 - Өөрийгөө оношлох сорилын хэсэг
 - Түвшин тогтоох сорилууд багтана.



ЮНЕСКО-ийн “ТХБ-2030” баримт бичигт тогтвортой хөгжлийн зорилгод хүргэх дэлхий нийтийн үйлийн хүрээ, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл тус бүрээр юу хийх хэрэгтэйг зааж өгөхийн зэрэгцээ улс орнуудад хандан 2020-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа үйлийн тэргүүлэх таван чиглэлд идэвхжүүлэн хөгжүүлэхийг уриалсан. Дэлхийн улсууд дээрх баримт бичгийг баримжаалан, өөрийн орны онцлогтой уялдуулан ТХБ-ыг дэмжин хөгжүүлэх бодлого, стратегийг боловсруулан хэрэгжүүлж байна. Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр ТХБ-II төслийн хүрээнд Олон улсын баримтлах бодлогын баримт бичиг, судалгааны үр дүн, хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагаас гарсан зөвлөмж, боловсролын ирээдүйн талаарх 4 гарын авлагын орчуулгыг эмхэтгэж хэвлүүллээ.



“Тогтвортой хөгжлийн боловсрол 2030: Монгол Улсын санаачилга”-ыг БСҮХ-гийн эрдэм шинжилгээний ажилтнууд болон БШУЯ-ны мэргэжилтнүүд ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссын дэмжлэгтэйгээр боловсруулсан. Уг санаачилгын бичгийн төслийг бусад яамд, агентлаг болон орон нутгийн төлөөлөлд танилцуулах, хэлэлцүүлэх, санал авах ажлыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулав. Энэхүү санаачилгад ЮНЕСКО-оос удирдамж болгосон Замын зураглалыг баримтлан бодлогыг уялдуулах, суралцахуйн орчныг хувирган өөрчлөх, сурган хүмүүжүүлэгчдийн чадавхыг бий болгох, залуучуудад боломж, эрх мэдэл олгох, орон нутгийн түвшний үйлийг хурдасгах гэсэн үйлийн тэргүүлэх таван чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагааг ялган тодорхойлсон болно.



НҮБ болон Монгол Улсын Засгийн газар одоогоос эхлээд 2030 он хүртэлх хугацаанд боловсролыг хувирган өөрчлөх шинэ буюу шинэчилсэн, үндэсний түвшний алс хэтийн зорилтыг тодорхойлоход тус дөхөм үзүүлэх зорилгоор оролцоог хангасан үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулахыг зорьсон. Энэхүү хэлэлцүүлгийг БШУЯ, БСҮХ зохион байгуулсан.

Үндэсний хэлэлцүүлэгт хүүхэд, залуучуудын, боловсролын, иргэний нийгмийн хэвлэл мэдээллийн үндэсний болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл болон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн төлөөлөл нийт 500 орчим хүн оролцож хэлэлцсэн 5 чиглэлээр, давхардсан тоогоор нийт 1000 гаран санал гаргасан байна.